

Хүнсний аюулгүй байдлын үндэсний
лавлагаа лабораторийн Ерөнхий захирлын
2026 оны 02 сарын 15 өдрийн
А/15 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

ҮР ЧАДВАРЫН СОРИЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН УДИРДАМЖ

Хамрах хүрээ

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, эм биобэлдмэлийн үйлдвэрлэлийн чиглэлээр нийслэл, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн үндэсний түвшинд итгэмжлэгдсэн хими, микробиологи, хорио цээрийн сорилтын лабораториуд гэрээний дагуу оролцоно.

Хөтөлбөрийн зорилго

Лабораториудын шинжилгээний үр дүнгийн үнэн зөв, найдвартай байдлыг бодитоор үнэлэх, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, чанарын тогтолцоог тасралтгүй сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хөтөлбөрийг зохион байгуулах чиглэл

1.Химийн сорилт - Багажит шинжилгээний аргаар жимсний жүүсэнд хуурай бодис (%), уламжлалт шинжилгээний аргаар хүнсний давсанд иодын агууламж (мг/кг) тодорхойлох;

2.Микробиологийн сорилт - Хүнсний бүтээгдэхүүн (шингэн, хуурай)-д халдварлуулсан нян тодорхойлох, ариутгаж савласан усанд нянгийн ерөнхий тоог тоолох;

3.Хорио цээрийн сорилт - Улаан буудайн 1000 үрийн жин тодорхойлно.

Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа

Тус хөтөлбөрийг 2026 оны 02 дугаар сарын 11-ны өдрөөс 06 дугаар сарын 19-ны өдрийг дуустал дараах дарааллын дагуу хэрэгжүүлнэ. Үүнд:

- Сорилтын дээж бэлтгэх: 2026.02.11 – 2026.03.20;
- Сорилтын дээж түгээх: 2026.03.23 – 2026.03.27;
- Сорилтын үр дүн хүлээн авах: 2026.04.20 – 2026.04.24;
- Сорилтын үр дүнг боловсруулах: 2026.04.27 – 2026.05.01;
- Тайлан нэгтгэх: 2026.05.04 – 2026.05.15;
- Тайлан хүргүүлэх: 2026.05.18 – 2026.05.22;
- Залруулах ажиллагаа: 2026.05.25 – 2026.06.19 болно.

Хөтөлбөрийн тайлан

Хөтөлбөрийн тайланг 2026 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн дотор оролцогч лабораториудад, Үндэсний итгэмжлэлийн төв болон Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлнэ. Мөн байгууллагын албан ёсны цахим хуудас (nfl.gov.mn)-т байршуулна.

УР ЧАДВАРЫН СОРИЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮЗҮҮЛЭЛТ

(Дэлгэрэнгүй)

Д/д	Хөтөлбөрийн чиглэл		Дээжийн нэр	Код	Үзүүлэлт	Аргын стандарт	Дээжийн хэмжээ	
1	Химийн сорилт	Багажит шинжилгээний арга	Төрөл бүрийн ундаа, жүүс	26-2501	<i>Хуурай бодис, %</i>	MNS 5321:2016	1 оролцогч-250 мл	
		Уламжлалт шинжилгээний арга	Хоолны давс	26-2502	<i>Иодын агууламж, мг/кг</i>	MNS 5168:2002	1 оролцогч-50г	
2	Микробиологийн сорилт	Илрүүлэх сорилт	Нунтаг борц	26-1924	<i>Listeria monocytogenes тодорхойлох</i>	MNS ISO 11290-1:2020	1 оролцогч-5,5г	
				26-1424	<i>Salmonella enterica</i>	MNS ISO 6579-1:2020	1 оролцогч-5,5г	
			Шар будаа	26-1224	<i>Shigella flexneri</i>	MNS ISO 21567-2011	1 оролцогч-12,5г	
			Алимны нухаш	26-1124	<i>Bacillus cereus</i>	MNS ISO 7932:1999	1 оролцогч-22.5г	
				26-6624	<i>Bacillus subtilis</i>		1 оролцогч-22.5г	
			Жүүс	26-2524	<i>Staphylococcus aureus тодорхойлох</i>	MNS ISO 6888-1:2011	1 оролцогч-20г	
				26-2324	<i>Escherichia coli тодорхойлох</i>	MNS ISO 7251:2023	1 оролцогч-20г	
			Шингэн тэжээлт орчин	26-1524	<i>Pseudomonas aeruginosa</i>	MNS ISO 13720-99	1 оролцогч-40мл	
				26-1924	<i>Enterococcus faecalis</i>	MNS ISO 5686:2006	1 оролцогч-40мл	
			Нунтаг ааруул	26-9124	<i>Penicillium rubens тодорхойлох</i>	MNS 5132:2002	1 оролцогч-15г	
			Тоо тоолох сорилт	Савласан ус	26-T18	<i>Bacillus cereus тоо тоолох</i>	MNS 0900:2018	1 оролцогч-25мл
			3	Хорио цээрийн шинжилгээ	Тоон шинжилгээ	Улаан буудай	26-ХЦ14	<i>1000 үрийн жин</i>